

НИЙГЭМ СУДЛАЛ. ЭЕШ. 2018 оны “А” хувилбар

1. Гэр бүлийн экзогами ёс аль нь вэ? /1оноо/

- A. Гэрлэлтийг тодорхой бүлгээс үл хамааруулан зохицуулдаг ёс
- B. Гэрлэлтийг тодорхой бүлгийн дотоодод нь баталгаажуулдаг ёс
- C. Гэр бүл болсон хосууд эхнэрийн эцэг эхийн гэрт амьдрах ёс
- D. Гэр бүл болсон хосууд нөхрийн эцэг эхийн гэрт амьдрах ёс
- E. Гэр бүл болсон хосууд шинэ нутаг сонгож, эцэг эхээсээ тусдаа амьдрах ёс

Зөв хариулт:

A.Гэрлэлтийг тодорхой бүлгээс үл хамааруулан зохицуулдаг ёсыг экзогами гэнэ.

Буруу хариултын тайлбар:

B. Гэрлэлтийг тодорхой бүлгийн дотоодод нь баталгаажуулдаг ёсыг эндогами гэнэ.

C. Гэр бүл болсон хосууд эхнэрийн эцэг эхийн гэрт амьдрах ёсыг матрилокаль гэнэ.

D. Гэр бүл болсон хосууд нөхрийн эцэг эхийн гэрт амьдрах ёсыг патрилокаль гэнэ.

E. Гэр бүл болсон хосууд шинэ нутаг сонгож, эцэг эхээсээ тусдаа амьдрах ёсыг неолокаль гэнэ.

2. Гэрлэх хэлбэрүүдийг зөв харгалзуулна уу? /2 оноо/

1	Моногами гэр бүл	A	Нэг эмэгтэй олон нөхөртэй гэрлэх
2	Полиандр гэр бүл	B	Нэг эрэгтэй олон эхнэртэй гэрлэх
3	Полигени гэр бүл	C	Нэг эрэгтэй нэг эмэгтэй хоорондоо гэрлэх

A. 1b2a3c B. 1a2c3b C. 1c2b3a D.1c2a3b E. 1b2c3a

Зөв хариулт: D.

1. Моногами гэр бүл c. Нэг эрэгтэй нэг эмэгтэй хоорондоо гэрлэх

2. Полиандр гэр бүл a. Нэг эмэгтэй олон нөхөртэй гэрлэх

3. Полигени гэр бүл b. Нэг эрэгтэй олон эхнэртэй гэрлэх

3. Нийгмийн гажуудлын төрөлд аль нь хамаарахгүй вэ? /2оноо/

- A.Хууль зөрчих B. Гэмт хэрэг үйлдэх C. Дээд боловсрол эзэмшээгүй байх
- D.Архинд донтох E.Хар тамхи хэрэглэх

Зөв хариулт: C. Гажуудал гэдэг нь нийгмийн хэм хэмжээнээс хазайсан бүхэн юм. Дээд боловсрол эзэмшээгүй байх нь нийгмийн хэм хэмжээнээс хазайгаагүй.

Буруу хариултын тайлбар: A. Хууль зөрчих B. Гэмт хэрэг үйлдэх D. Архинд донтох E. Хар тамхи хэрэглэх нь нийгмийн хэм хэмжээнээс хазайсан үйлдлүүд учир гажуудлын төрөлд хамаарна.

4. Нийгмийн тогтолцооны макро бүтцэд бус харин нийгмийн амьдралын микро тал буюу хүмүүсийн өдөр тутмын харилцаанд илүүтэй анхаардаг нийгмийг судлах онолын хандлага аль нь вэ? /1оноо/
- A. Бүтэц-чиг үүргийн хандлага
 - B. Харилцан үйлдлийн хандлага
 - C. Тогтолцооны хандлага
 - D. Зөрчилдөөний хандлага
 - E. Шалтгаант чанарын хандлага

Зөв хариулт: B. Харилцан үйлдлийн хандлага нь нийгмийн тогтолцооны макро бүтцэд бус харин нийгмийн амьдралын микро тал буюу хүмүүсийн өдөр тутмын харилцааны үйлдвэржсэн нийгэм, Аж үйлдвэржсэний дараах нийгэм илүүтэй анхаардаг.

Буруу хариултын тайлбар:

A. Бүтэц-чиг үүргийн хандлага: Энэ хандлага нь нийгэм харилцан хамаарал бүхий бүрэлдэхүүн хэсгүүдтэй, тэдгээр нь нийгмийн оршин тогтнол, хөгжилд зохих үүрэг гүйцэтгэж байдаг гэж үздэг.

C. Тогтолцооны хандлага: Нийгмийг нягт хэлхээ холбоонд нь оршдог элементүүдийн нийтлэг тогтолцоо гэж үздэг. Нийгмийн асуудалд хандах энэхүү хандлагыг тогтолцооны хандлага гэж нэрлэдэг

D. Зөрчилдөөний хандлага: Нийгмийн зөрчилдөөнт, байнгын хувьсан өөрчлөгдөгч шинжийг онцолдог. Нийгэм бол нийгэм, эдийн засгийн нөөц баялгийн төлөө өөр хоорондоо өрсөлдөгч бүлгүүдээс тогтдог гэж үздэг.

E. Шалтгаант чанарын хандлага: Нийгэмд тогтолцоот чанарынх нь талаас хандах хандлагыг шалтгаант чанар ба үүргийн талаас нь хандах хандлагаар баяжуулж болно. Шалтгаант чанарын хандлага нь марксизмд илүүтэйгээр тодордог. Д. Буян. Нийгмийн тухай мэдлэг

5. Нийгмийн байр суурийг илтгэх олдмол статусын жишээ аль нь вэ? /1 оноо/
- A. Би Булган аймагт төрсөн
 - B. Миний аав Алаг адуу овогтой
 - C. Би 11 настай
 - D. Би сагсан бөмбөгийн I зэрэгтэй
 - E. Миний ээж Монгол үндэстэн

Зөв хариулт: D. Хүний өөрийнх нь хичээл зүтгэл, чармайлтаар олж авдаг нийгмийн байр суурь нь олдмол статус юм. Би сагсан бөмбөгийн I зэрэгтэй гэдэг нь олдмол статус юм.

Буруу хариултын тайлбар: Тодорхой нэг хүний өвөрмөц авъяас чадвар, өөрт нь заяагдмал, өөрөө сонгох боломжгүй байдаг нийгмийн байр суурь нь төрөлх статус юм.

A. Би Булган аймагт төрсөн

B. Миний аав Алаг адуу овогтой

C. Би 11 настай

E. Миний ээж Монгол үндэстэн байх нь төрөлх статус юм.

6. "Ан агнуур, түүврийн нийгэм" хэмээх ойлголт нийгмийн хэв маягийг ангилал онол, ангиллын алинд ньхамаарах вэ? /1 оноо/
- A. Морганы үзэл
 - B. Формацын онол
 - C. Иргэншлийн онол ангилал
 - D. Өсөлтийн үе шатны онол
 - E. А.Ленски, Ж.Ленски нарын ангилал

Зөв хариулт: E. А.Ленски, Ж.Ленски нарын ангилал Ан агнуур, түүврийн нийгэм, Тариалан мал аж ахуйн нийгэм, Хөдөө аж ахуйн нийгэм, Аж үйлдвэржсэн нийгэм, Аж үйлдвэржсэний дараах нийгэм

Буруу хариултын тайлбар:

A. Морганы үзэл: Зэрлэг үе, Бүдүүлэг үе, Соёлт үе

B. Формацын онол: Хүй нэгдлийн нийгэм, Боол эзэмшлийн нийгэм, Феодалын нийгэм, Капиталист нийгэм, Социалист буюу коммунист нийгэм

C. Иргэншлийн онол: Үүсэл-Өсөлт-Бууралт-Уналт-Бутрал

D. Өсөлтийн үе шатны онол: Уламжлалт нийгэм, Шилжилтийн нийгэм, Нисэлтийн үе, Боловсорсон үе, Нийтийн хэрэглээний өндөр түвшинд хүрсэн үе

7. Нийгмийн хөгжлийн үе шат бүхэн өмнөх үеэсээ цаг хугацааны хувьд богино үргэлжилсэн байдаг. Хамгийн богино хугацаанд үргэлжилж буй нийгмийн хэв маяг аль нь вэ? /1 оноо/
- A. Аж үйлдвэржсэний дараах нийгэм B. Ан агнуур, түүврийн нийгэм
C. Аж үйлдвэржсэн нийгэм D. Хөдөө аж ахуйн нийгэм
E. Тариалан, мал аж ахуйн нийгэм

Зөв хариулт: А. Нийгмийн ямар нэгэн үе шат бүхэн өмнөх үеэсээ цаг хугацааны хувьд богино үргэлжилдэг бөгөөд энэхүү хуулийг түүхийн хурдацын хууль буюу хандлага гэдэг. А.Ленски, Ж.Ленски нарын ангиллаар аж үйлдвэржсэний дараах нийгэм нь хамгийн сүүлд байгаа учраас хамгийн богино хугацаанд үргэлжилсэн. Ан агнуур, түүврийн нийгэм, Тариалан мал аж ахуйн нийгэм, Хөдөө аж ахуйн нийгэм, Аж үйлдвэржсэн нийгэм, Аж үйлдвэржсэний дараах нийгэм

Буруу хариултын тайлбар:

А.Ленски, Ж.Ленски нарын ангиллаар аж үйлдвэржсэний дараах нийгэм нь хамгийн сүүлд байгаа учраас хамгийн богино хугацаанд үргэлжилсэн. Бусад нийгмүүд нь аж үйлдвэржсэний дараа нийгмээс өмнө байгаа бөгөөд цаг хугацааны хувьд аж үйлдвэржсэний дараах нийгмээс урт хугацаанд үргэлжилсэн. Ан агнуур, түүврийн нийгэм Тариалан мал аж ахуйн нийгэм, Хөдөө аж ахуйн нийгэм, Аж үйлдвэржсэн нийгэм, Аж үйлдвэржсэний дараах нийгэм.

8. Үйлдвэржилтийн харилцааны үр дүнд тогтсон, эдийн засгийн баялгийн ялгаанаас үүдэлтэй, хувийн байр сууриа өөрчлөх боломжтой давхраажилтын хэв маяг аль нь вэ? /1 оноо/
- A. Боолчлол B. Каст C. Язгуур угсаа D. Анги E. Угсаа гарал

Зөв хариулт: D. Үйлдвэржилтийн харилцааны үр дүнд тогтсон, эдийн засгийн баялгийн ялгаанаас үүдэлтэй, хувийн байр сууриа өөрчлөх боломжтой давхраажилтын хэв маяг бол анги юм.

Буруу хариултын тайлбар:

A. Боолчлол: Нэг нь нөгөөгийнхөө өмч болж байдаг, албадлагын хөдөлмөрийн харилцаанд тулгуурласан давхраажилтын хэв маяг

B. Каст. Шашны номлолоор зөвтгөгдөн, хөдөлмөрийн хуваарьтай нь холбогдон тодорхойлогдсон, хувийн байр суурийг өөрчлөх ямар ч боломжгүй хаалттай давхраажилтын тогтолцоо юм.

C. E. Язгуур угсаа (Угсаа гарал): Улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхээрээ ялгаатай, эрх зүйн хувьд баталгаажсан, хаалттай давхраажилтын систем бол язгуур юм.

9. Эртний Энэтхэгийн кастын тогтолцооны Брахман хэмээх давхраанд ямар хүмүүсийг хамааруулдаг байсан бэ? /2 оноо/
- A. Газар тариалан эрхлэгчид B. Цэргийнхэн болон хууль сахиулагчид
C. Санваартан болон сэтгэгчид D. Худалдаачид
E. Гар урчууд болон үйлчлэгч нар

Зөв хариулт: C. Эртний Энэтхэгийн кастыг 4 давхраагаар авч үздэг. Брахман: Энэ кастад санваартан, багш, сэтгэгчид багтана.

Буруу хариултын тайлбар: A, B, D, E Эртний Энэтхэгийн кастыг 4 давхраагаар авч үздэг.

Кшатрий: Төрийн захиргааныхан, цэргийнхэн, хууль сахиулагчид багтана.

Вяшняя: Газар тариалан эрхлэгчид, үхэр маллагч, худалдаачид энэ кастад багтана.

Шудра: Энэхүү кастад гар урчууд болон үйлчлэгчид багтана.

10. Э. Кассирер нь овог аймгуудын хэл, домог, шашин, урлаг зэрэг соёлын үзэгдлүүдийг судалсан соёл судлаач эрдэмтэн юм. Дараах өгөгдлүүдийн аль нь түүний үзэл санааг тодорхойлох вэ? /1 оноо/
- A. Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар дадлуудыг багтаасан цогц бүхэллэг зүйл юм.
 - B. Хүн бол бэлгэ тэмдгүүдийг бүтээдэг амьтан
 - C. Соёл бол өв уламжлан авсан бүтээл, юмс, техникийн үйл ажиллагаа, үзэл санаа, зан үйл, үнэт зүйлс мөн.
 - D. Дэлхийн нэг нэгдмэл соёл байх боломжгүй, харин өөр өөрийн хувь тавилан бүхий янз бүрийн соёл байна
 - E. Соёлын хэлбэрт олон тооны нийтлэг ойлголт, зарчмууд илэрч байдаг.

Зөв хариулт: B. А. Кассирер нь хүн бол оюун ухаантай амьтан гэдэг шиг “Хүн бол бэлгэ тэмдгүүдийг бүтээдэг амьтан” гэж тодорхойлсон байна.

Буруу хариултын тайлбар:

- A. Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар дадлуудыг багтаасан цогц бүхэллэг зүйл юм. Э. Тайлор
- C. Соёл бол өв уламжлан авсан бүтээл, юмс, техникийн үйл ажиллагаа, үзэл санаа, зан үйл, үнэт зүйлс мөн. Б.Малиновский
- D. Дэлхийн нэг нэгдмэл соёл байх боломжгүй, харин өөр өөрийн хувь тавилан бүхий янз бүрийн соёл байна. О.Шпенглер
- E. Соёлын хэлбэрт олон тооны нийтлэг ойлголт, зарчмууд илэрч байдаг. Ж. Мердок

11. Нийгэмд тогтсон хэм хэмжээ алдагдсаны улмаас соёлын нэгдэл зөрчилддөг. Энэ нь онолын хувьд аль ойлголтод хамаарах вэ? /1 оноо/
- A. Соёлын нэвчих үзэгдэл
 - B. Соёлын хожимдолт
 - C. Харийн соёлын ноёрхол
 - D. Соёлын гажилт
 - E. Соёлын холбоо

Зөв хариулт: D. Нийгэмд тогтсон хэм хэмжээ алдагдсаны улмаас соёлын нэгдэл зөрчилдөхийг соёлын гажилт гэнэ.

Буруу хариултын тайлбар:

- A. Соёлын нэвчих үзэгдэл: Булаан эзлэх, шашин дэлгэрүүлэх, мэдээллийн хэрэгслийн нөлөө зэрэг олон сувгуудаар соёлын үнэт зүйл нэг бүлгээс нөгөөд, Нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явц нь соёлын нэвчих үзэгдэл юм.
- B. Соёлын хожимдолт: Материаллаг амьдралын өөрчлөлтүүд нь зан заншил, итгэл үнэмшлийн өөрчлөлтөөс түрүүлж байж болно. Энэ нь соёлын хожимдолт юм.
- C. Харийн соёлын ноёрхол Харийн соёлын ноёрхол нь колончлолын бодлогын үед илэрдэг. Харийн болон үндэсний соёл хоорондоо зөрчилддөг үзэгдэл
- D. Соёлын холбоо Соёлын бие биентэйгээ харилцах үзэгдлийг соёлын холбоо гэдэг. Д. Буян. Нийгмийн тухай мэдлэг.

12. Булаан эзлэх, шашин дэлгэрүүлэх, мэдээллийн хэрэгслийн нөлөө зэрэг олон сувгуудаар соёлын үнэт зүйл нэг бүлгээс нөгөөд, нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явц ньюм. /1 оноо/
- A. Соёлын хуримтлал
 - B. Соёлын түгээмэл шинж
 - C. Соёлын цочирдол
 - D. Соёлын хожимдолт
 - E. Соёлын нэвчилт

Зөв хариулт: E. Булаан эзлэх, шашин дэлгэрүүлэх, мэдээллийн хэрэгслийн нөлөө зэрэг олон сувгуудаар соёлын үнэт зүйл нэг бүлгээс нөгөөд, нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явц нь соёлын нэвчих үзэгдэл юм.

Буруу хариултын тайлбар: A. Соёлын хуримтлал: Соёлын өөрчлөлтийн эх үүсвэрийн үр дүнд улс үндэстэн болон дэлхийн соёлын өв баяжин хуримтлагдах

B. Соёлын түгээмэл шинж Соёлын хэлбэрт олон тооны нийтлэг ойлголт, зарчмууд илэрч байдаг. Үүнийг соёлын нийтлэг буюу түгээмэл шинж гэдэг.

с. Соёлын цочирдол Соёл судлалын ухаанд соёлын шок гэсэн ойлголт байдаг. Үүнийг соёлын цочирдол гэж нэрлэдэг.

D. Соёлын хожимдолт Материаллаг амьдралын өөрчлөлтүүд нь зан заншил, итгэл үнэмшлийн өөрчлөлтөөс түрүүлж байж болно. Энэ нь соёлын хожимдолт юм.

13. Европт шилжин суурьшсан Халимагуудыг оросжсон гэх боловч буддын шашин, монгол хэлээ эрхэмлэдэг, цагаан сараа тэмдэглэсээр ирсэн гэвэл энэ нь соёлын ямар шинжийг илтгэн харуулж байна вэ? /2 оноо/

A. Соёлын тогтонги шинж B. Соёлын хувирамтгай шинж C. Соёлын өөрчлөмтгий шинж
D. Соёлын хөдөлгөөнт шинж E. Соёлын тогтворгүй шинж

Зөв хариулт: A. Европт шилжин суурьшсан Халимагуудыг оросжсон гэх боловч буддын шашин, монгол хэлээ эрхэмлэдэг, цагаан сараа тэмдэглэсээр ирсэн гэвэл энэ нь соёлын харьцангуй тогтвортой шинжийг илтгэн харуулж байна. Соёлын бусдын нөлөөнд автдаггүй, харьцангуй тогтвортой шинж чанарыг соёлын тогтонги буюу статик шинж гэнэ.

Буруу хариултын тайлбар: B, C, D, E Соёлын өөрчлөмтгий, хөдөлгөөнт шинж чанарыг соёлын динамик шинж гэнэ. Соёлын хөдөлгөөнт, хувирамтгай, өөрчлөмтгий, тогтворгүй шинжүүд нь динамик шинжид багтана.

14. "Соёлыг хүний үйл ажиллагааны үр дүн" гэдэг утгаар нь юу гэж ангилдаг вэ? /1 оноо/

- A. Бүс нутгийн, үндэсний, олон улсын
- B. Ардын, нийтийн, сонгодог
- C. Зонхилох, сөрөг, дагуул
- D. Биет ба биет бус
- E. Нэг хэв загварын ба олон хэв загварын

Зөв хариулт: D. Соёлыг хүний үйл ажиллагааны үр дүнгэдэг утгаар нь судлаачид биет(эдийн) ба биет бус(оюуны) гэсэн хоёр хэлбэртэй гэж үздэг.

Буруу хариултын тайлбар:

A. Бүс нутгийн, үндэсний, олон улсын Соёлыг түвшингээр нь олон улсын болон үндэсний гэж ангилдаг.

B. Ардын, нийтийн сонгодог Хэн бүтээсэн, ямар түвшний соёл бэ? гэдгээс нь хамааруулан соёлыг ардын, нийтийн сонгодог гэж ангилдаг.

C. Зонхилох, сөрөг, дагуул Соёлыг зонхилогч соёл, дэд соёл, сөрөг соёл гэж ангилдаг.

Зонхилогч соёл: Тодорхой цаг үед нийгмийн гишүүдийн дийлэнхийн амьдрах зан үйл, үйлдлийн загварыг тодорхойлогч соёл Сөрөг соёл: Зонхилох соёлтой зөрчилдөж байдаг соёл Дэд соёл: Нийгэмд зонхилогч соёл оршин байхын зэрэгцээ нийгмийн бүлгүүд нь харилцан адилгүй ялгаатай өөрийн гэсэн соёлыг бий болгоно. Үүнийг дэд соёл гэнэ.

E. Нэг хэв загварын ба олон хэв загварын

Олон хэв загварын соёл: Дотооддоо онцлог ялгаа бүхий соёл бүрэлдэх хийгээд гадны соёлын элементүүд нэвтрэн шингэх боломжтой соёл

Нэг хэв загварын соёл: Нэг ерөнхий итгэл үнэмшил, үнэт зүйлстэй соёлын өөр элементүүд нэвтрэх боломжгүй соёл

15. Хувь хүний соёлын доод түвшин ямар хэрэгцээ давамгайлж байгаагаар тодорхойлогдох вэ? /1 оноо/
- A. Өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ B. Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ
C. Материаллаг хэрэгцээ D. Оюуны хэрэгцээ E. Бүтээн туурвих хэрэгцээ

Зөв хариулт: C. Ямар хэрэгцээ давамгайлж байгаагаар нь соёлын түвшинг авч үзэх юм бол хамгийн доод түвшин нь материаллаг хэрэгцээгээр тодорхойлогдоно.

Бүрүү хариултын тайлбар:

- A. Өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ
B. Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ Хувь хүний хоёр дахь буюу дунд түвшин нь өөрийгөө илэрхийлэх болон, өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ давамгайлсанаар тодорхойлогдоно.
D. Оюуны хэрэгцээ
E. Бүтээн туурвих хэрэгцээ Хувь хүний соёлын дээд буюу элит түвшин нь бүтээн туурвих, оюуны хэрэгцээгээр тодорхойлогдоно.

16. Иргэн Дорж нь өндөр боловсролтой их сургуулийн профессор бөгөөд бүтээн туурвих, бүтээлч байдал, бусдыг хүндлэх нинжин сэтгэл, сайн үйлийг амьдралдаа ямагт эрхэмлэн хэрэгжүүлэгч нэгэн юм. Түүний амьдралын хэв маяг нь хувь хүний соёлын ямар түвшинг илэрхийлж байна вэ? /2 оноо/
- A. Соёлын материаллаг түвшин B. Соёлын хоёрдогч түвшин C. Соёлын дунд түвшин
D. Соёлын доод түвшин E. Соёлын дээд түвшин

Зөв хариулт: D Бүтээн туурвих, бүтээлч байдал, бусдыг хүндлэх нинжин сэтгэл, сайн үйлийг амьдралдаа ямагт эрхэмлэх нь хувь хүний соёлын дээд буюу элит түвшин юм.

Бүрүү хариултын тайлбар:

- A. Соёлын материаллаг түвшин
B. Соёлын доод түвшин Хүний материаллаг хэрэгцээгээр хувь хүний соёлын доод түвшин тодорхойлогдоно.
C. Соёлын хоёрдогч түвшин
D. Соёлын дунд түвшин
Хүний өөрийгөө илэрхийлэх болон өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ нь хувь хүний хоёр дахь буюу дунд түвшинг тодорхойлно.

17. Ёс суртахууны хэм хэмжээ нь хувь хүний үйл ажиллагааг бусад хүмүүс болон нийгмийн эрх ашиг сонирхолтой нийцүүлэн чиглүүлж байдаг. Энэ нь ёс суртахууны хэм хэмжээний аль үүрэгт хамаарах вэ? /1 оноо/
- A. Хуримтлуулах, хадгалах үүрэг B. Төлөвшүүлэх үүрэг C. Танин мэдэхүйн үүрэг
D. Үнэлэмж баримжааллын үүрэг E. Зохицуулах үүрэг

Зөв хариулт: E Хувь хүний үйл ажиллагааг бусад хүмүүс болон нийгмийн эрх ашиг сонирхолтой нийцүүлэн чиглүүлж байдаг. Энэ нь ёс суртахууны хэм хэмжээний зохицуулах үүрэг юм.

Бүрүү хариултын тайлбар:

- A. Хуримтлуулах, хадгалах үүрэг Энэхүү үүрэг нь ёс суртахууны хэм хэмжээний танин мэдэхүйн үүрэгт хамаарна.
B. Төлөвшүүлэх үүрэг Ёс суртахууныг өөриймшүүлсэний үр дүнд хүмүүс өөрийн үйлдэл, үйл ажиллагааг аа хянаж, удирдаж байдаг. Энэ нь ёс суртахууны хэм хэмжээний төлөвшүүлэх үүрэг юм.
C. Танин мэдэхүйн үүрэг Ёс суртахуунаар дамжин хүмүүс зан харилцааны дүрэм журам, нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар мэдлэг эзэмшиж байдаг. Энэ нь ёс суртахууны хэм хэмжээний танин мэдэхүйн Үүрэг юм.
D. Үнэлэмж баримжааллын үүрэг Хүмүүс өөрийгөө авч явах чиг баримжаа эзэмшиж, өөрийн болон бусдын ёс суртахууны төлөвшилд үнэгээ өгч байдаг. Энэ нь ёс суртахууны хэм хэмжээний үнэлэмж баримжааллын үүрэг юм.

18. Ёс заншлыг тодорхойлох онцлог шинжийг дурдахдаа хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? /2оноо/
- A. Үндэстнийхээ олон зууны туршлагыг хуримтлуулах, хадгалах, хойч үедээ өвлүүлэх өвөрмөц арга юм.
 - B. Тодорхой нөхцөлд биеэ хэрхэн авч явахыг ёсчлон тодорхой зааж өгдөг.
 - C. Үндэстэн бүхэн өөрийн гэсэн ёс заншилтай.
 - D. Албан ёсны хэм" хэмжээ бөгөөд дагаж мөрдүүлэх явдлыг төрийн зүгээс хянаж, шалгаж байдаг.
 - E. Тухайн ард түмэнтэй хамт үүсч, ёс суртахууны ухамсрын төлөвшилд онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Зөв хариулт: D. Ёс заншил нь албан бус хэм хэмжээ юм. Иймээс D хувилбар нь ёс заншлыг тодорхойлох онцлог шинжид хамааралгүй юм.

Буруу хариултын тайлбар:

- A. Үндэстнийхээ олон зууны туршлагыг хуримтлуулах, хадгалах, хойч үедээ өвлүүлэх өвөрмөц арга юм.
- B. Тодорхой нөхцөлд биеэ хэрхэн авч явахыг ёсчлон тодорхой зааж өгдөг.
- C. Үндэстэн бүхэн өөрийн гэсэн ёс заншилтай.
- E. Тухайн ард түмэнтэй хамт үүсч, ёс суртахууны ухамсрын төлөвшилд онцгой үүрэг гүйцэтгэдэг.

19. Улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнийн дүнг.....гэнэ. /1 оноо/
- A. Цэвэр экспорт
 - B. Үндэсний нийт бүтээгдэхүүн
 - C. Дотоодын нийт бүтээгдэхүүн
 - D. Үндэсний орлого
 - E. Дотоодын хөрөнгө оруулалт

Зөв хариулт: C. Улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнийн дүнг ДНБ гэнэ.

Буруу хариултын тайлбар:

- A. Цэвэр экспорт: Бүтээгдэхүүн үйлчилгээний экспортоос импортыг хассан дүн.
- B. Үндэсний нийт бүтээгдэхүүн: Дотоод болон хилийн чанад дахь Монголын хөрөнгө оруулалттай ААН-үүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг
- D. Үндэсний орлого: ҮЦБ-ээс худалдаа үйлчилгээний шууд бус татварыг хасаад үлдэж байгаа хэсгийг хэлнэ.
- E. Дотоодын хөрөнгө оруулалт: Капиталын шинэ хуримтлалын үнэ цэн буюу үндсэн хөрөнгө шинээр худалдан авах үйл ажиллагааг ойлгодог

20. Дотоодын нийт бүтээгдэхүүнд оруулж тооцох бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний жишээ аль нь вэ? /2оноо/
- A. Бялууны үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох үр тариа болон гурилын өртөг
 - B. Батын аав амралтын өдрөөр машиндаа засвар хийв.
 - C. Болд хашаандаа гэр бүлийн хэрэгцээндээ зориулж төмс тарив.
 - D. Талхны үйлдвэрийн худалдан авсан гурилын өртөг
 - E. Тухайн жилд үйлдвэрлэсэн талхны үнэ

Зөв хариулт: Е. Талх нь эцсийн хэрэглээнд зориулагдсан бүтээгдэхүүн учир ДНБ-д Тооцогдоно
Буруу хариултын тайлбар:

А. Бялууны үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болох үр тариа болон гурилын өртөг: Эцсийн хэрэглээнд зориулагдаагүй бүтээгдэхүүн үйлчилгээг ДНБ-д оруулж тооцохгүй. Жилийн турш тариалж ургуулсан үр тариаг гурилын үйлдвэр худалдан аваад үйлдвэрлэсэн гурилыг бялууны үйлдвэр худалдан авч түүгээр бялуу үйлдвэрлэдэг. Энэ тохиолдолд ДНБ зөвхөн бялууны өртгөөр нэмэгдэнэ.

В. Батын аав амралтын өдрөөр машиндаа засвар хийв: ДНБ-д тооцогдохгүй. Учир нь үйлдвэрлэл нь ямар нэгэн төлбөр шаарддаггүй. Зах зээлд борлуулдаггүй бүтээгдэхүүн үйлчилгээг ДНБ-д оруулж тооцохгүй.

с. Болд хашаандаа гэр бүлийн хэрэгцээндээ зориулж төмс тарив: ДНБ-ийг нэмэгдүүлэхгүй. Зах зээлд борлуулдаггүй бүтээгдэхүүн үйлчилгээг ДНБ-д оруулж тооцохгүй.

Д. Талхны үйлдвэрийн худалдан авсан гурилын өртөг:Эцсийн хэрэглээнд зориулагдаагүй бүтээгдэхүүн үйлчилгээг ДНБ-д оруулж тооцохгүй. Жилийн турш тариалж ургуулсан үр тариаг гурилын үйлдвэр худалдан аваад үйлдвэрлэсэн гурилыг талхны үйлдвэр худалдан авч түүгээр талх үйлдвэрлэдэг. Энэ тохиолдолд ДНБ зөвхөн талхны өртгөөр нэмэгдэнэ.

21. Хүснэгт дэх мэдээллийг уншаад доорх асуултын зөв хариултыг олно уу. Иргэн Г нэгэн хувьцаат компанийн 200 ширхэг хувьцааг 2018 оны 1-р сарын 5-ны өдөр худалдан авч 2018 оны 3-р сарын 5-ны өдөр эргүүлэн худалдсан бол ханшийн өөрчлөлтөөс хэдэн төгрөгийн ашиг олсон бэ? /2 оноо/

Тухайн хувьцаат компанийн ханшийн мэдээ

Хувьцааны дундаж үнэ, төг	Он, сар
20350	2018.01.05
20850	2018.03.05

A. 101000 B. 505 C. 41205 D. 4070000 E. 4171000

Зөв хариулт: А.Иргэн Г 200 ширхэг хувьцааг 4070000-өөр худалдан аваад буцааж 4171000-өөр зарсан. Ханшийн өөрчлөлтөөс 101000-ийн ашиг олсон.

Буруу хариултын тайлбар:

В. 505- 2018.03.05-ны өдрийн нэгж хувьцааны ханшаас 2018.01.05-ны өдрийн нэгж хувьцааны ханшийг хассан дүн.

С. 41205- 2018.03.05-ны өдрийн нэгж хувьцааны ханшин дээр 2018.01.05-ны өдрийн нэгж хувьцааны ханшийг нэмсэн дүн

Д. 4070000-Анх 200 ширхэг хувьцааг худалдан авсан мөнгөн дүн

Е. 4171000-200 ширхэг хувьцааг худалдсан мөнгөн дүн.

22. Арилжааны банкны зарим үүргийг хүснэгтэд үзүүлжээ. Хүснэгтийн аль хэсэгт алдаатай өгөгдөл байна вэ? /1оноо/

1.Зээл олгох	2. Мөнгөн хадгаламж хүлээн авах Арилжааны банкны ерак
3. Харилцагчдын төлбөр тооцоо арилжааны банк	4. Төрийн мөнгөний бодлого хэрэгжүүлэх дамжуулах

A. 1 B.2 C.3 D.4 E.2 ба 3

Зөв хариулт: D. Төрийн мөнгөний бодлого хэрэгжүүлэх нь төв банкны үүрэгт хамаарна.

Буруу хариултын тайлбар:

1.Зээл олгох 2. Мөнгөн хадгаламж хүлээн авах 3. Харилцагчдын төлбөр Тооцоог дамжуулах нь арилжааны банкны үүрэгт хамаарна.

23. Гүйлгээнд их хэмжээний мөнгө бий болж, түүгээр худалдан авах барааны тоо хэмжээ бага байгаагаас барааны үнэ өсдөг. Энэ нь инфляци үүсэх аль шалтгаанд хамаарах вэ? /1оноо/
- A. Ашгаас үүдэлтэй инфляци B. Зардлаас үүдэлтэй инфляци
C. Эрэлтээс үүдэлтэй инфляци D. Борлуулалтаас үүдэлтэй инфляци
E. Түвшнээс хамааралтай инфляци

Зөв хариулт: C. Гүйлгээнд их хэмжээний мөнгө бий болж, түүгээр худалдан авах барааны тоо хэмжээ бага байгаагаас барааны үнэ өсдөг. Энэ нь эрэлтээс үүдэлтэй инфляци юм.

Бүрүү хариултын тайлбар:

- A. Ашгаас үүдэлтэй инфляци: Энэ инфляци үүсэх шалтгаан биш. Ийм нэршил байхгүй.
B. Зардлаас үүдэлтэй инфляци: Үйлдвэрлэлийн өртөг өссөнөөр бараа бүтээгдэхүүний үнэ өсдөг. Үүнийг зардлаас үүдэлтэй инфляци гэнэ.
D. Борлуулалтаас үүдэлтэй инфляци: Энэ инфляци үүсэх шалтгаан биш. Ийм нэршил байхгүй.
E. Түвшнээс хамааралтай инфляци: Инфляцийн түвшин гэсэн ойлголт байдаг. Харин инфляци үүсэх шалтгаан биш. Ийм нэршил байхгүй.

24. Бүтцийн ажилгүйдлийг тодорхойлох жишээ аль нь вэ? /2 оноо/
- A. Эдийн засгийн хямрал үргэлжилж, олон үйлдвэрүүд үйл ажиллагаагаа хумьж, зарим нь зогсоожээ. Үүний улмаас үйлдвэрийн олон тооны ажилчид ажлаасаа халагдсан байна.
B. Уул уурхайн салбарын эдийн засагт эзлэх хувийн жин буурч, мэдээлэл технологийн салбарын эзлэх хувь эрс нэмэгдсэн байна. Үүний улмаас уурхайн ажилчид олноороо ажилгүй болсон.
C. Өвлийн улирал эхэлснээр аялал жуулчлалын компаниуд үйл ажиллагаагаа түр зогсоов. Үүний улмаас тодорхой тооны хүмүүс ажилгүй болов
D. Доржийн цалингийн хэмжээ амьдралд нь хүрэлцэхгүй байгаа тул өөр өндөр цалинтай ажил хайхаар ажлаас гарсан.
E. Хандаагийн нөхөр нийслэлд ажиллахаар томилогдсон тул Хандаа хотод ирээд хэсэг хугацаанд ажилгүй байсан.

Зөв хариулт: B. Эдийн засгийн хөгжлийн дагуу бүтцийн өөрчлөлт гарч нэг салбар, мэргэжлийн цар хүрээ хумигдан, шинэ салбар мэргэжлийн шаардлага өссөнтэй холбоотой ажилгүйдлийг бүтцийн ажилгүйдэл гэдэг.

Бүрүү хариултын тайлбар:

- A. Эдийн засгийн хямрал үргэлжилж, олон үйлдвэрүүд үйл ажиллагаагаа хумьж, зарим нь зогсоожээ. Үүний улмаас үйлдвэрийн олон тооны ажилчид ажлаасаа халагдсан байна. Энэ нь мөчлөгийн ажилгүйдлийн жишээ юм.
B. Өвлийн улирал эхэлснээр аялал жуулчлалын компаниуд үйл ажиллагаагаа түр зогсоов. Үүний улмаас тодорхой тооны хүмүүс ажилгүй болов. Энэ нь улирлын ажилгүйдлийн жишээ юм.
C. Доржийн цалингийн хэмжээ амьдралд нь хүрэлцэхгүй байгаа тул өөр өндөр цалинтай ажил хайхаар ажлаас гарсан. Энэ нь шилжилтийн буюу завсрын ажилгүйдлийн жишээ юм.
D. Хандаагийн нөхөр нийслэлд ажиллахаар томилогдсон тул Хандаа хотод ирээд хэсэг хугацаанд ажилгүй байсан. Энэ нь шилжилтийн буюу завсрын ажилгүйдлийн жишээ юм.

25. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлогыг төрийнгэнэ. /1 оноо/

- A. Мөнгөний бодлого B. Сангийн бодлого C. Зээлийн бодлого
D. Хүүгийн бодлого E. Хөрөнгө оруулалтын бодлого

Зөв хариулт: B. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлогыг төрийн сангийн буюу төсвийн бодлого гэнэ.

Буруу хариултын тайлбар:

- A. Мөнгөний бодлого
C. Зээлийн бодлого
D. Хүүгийн бодлого Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлогыг төрийн мөнгө-зээлийн бодлого гэнэ.
E. Хөрөнгө оруулалтын бодлого: Гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн бодлого

26. Шууд татвар аль нь вэ? /1 оноо/

- A. Тамхины албан татвар B. Нэмэгдсэн өртгийн албан татвар. C. Архины албан татвар
D. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын. E. Бензинд ногдуулах албан татвар

Зөв хариулт: D. Татварыг шууд ба шууд бус гэж ангилдаг. Шууд татвар гэдэг нь тухайн улсын иргэн бүрээс, үйл ажиллагаа явуулж буй ААН бүрээс авах татвар. Шууд татварын хамгийн түгээмэл хэлбэр нь хувь хүний орлогын албан татвар, ААН-үүдийн орлогын албан татвар юм.

Буруу хариултын тайлбар: Татварыг шууд ба шууд бус гэж ангилдаг. Шууд бус татвар нь тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулж буй хүмүүс, ААН-ээс авах татвар. Шууд татварын түгээмэл хэлбэр нь нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар юм.

27. Д. Моррисын боловсруулсан амьдралын чанарын индекс нь дараах гурван үзүүлэлтээр тодорхойлогдоно. Гүйцээж бичнэ үү. /1 оноо/

1. Нялхсын эндэгдэл 2. Амьдралын түвшин буюу насжилт 3.....
A. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ B. Бичиг үсэг тайлагдсан байдал
C. Байгаль орчин D. Нийгмийн байдал E. Эдийн засаг

Зөв хариулт: B. Д. Моррисын боловсруулсан амьдралын чанарын индекс нь нялхсын эндэгдэл, амьдралын түвшин буюу насжилт, бичиг үсэг тайлагдсан байдалгэсэн гурван үзүүлэлтээр тодорхойлогдоно.

Буруу хариултын тайлбар: A. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь хүний хөгжлийн индексийг тооцоход ордог үзүүлэлт

- C. Эдийн засаг
D. Нийгмийн байдал
E. Байгаль орчин нь тогтвортой хөгжлийн тулгын гурван үзүүлэлт юм.

28. Бүх ард түмний санал асуулгад оролцох нь улс төрийн оролцооны аль хэлбэрт хамаарах вэ? /1 оноо/

- A. Нийцгүй улс төрийн оролцоо B. Нийцтэй улс төрийн оролцооны идэвхтэй хэлбэр
C. Идэвхгүй улс төрийн оролцоо D. Тогтоосон хэм хэмжээг зөрчсөн оролцоо
E. Нийцгүй улс төрийн оролцооны идэвхтэй хэлбэр

Зөв хариулт: B. Тухайн үед нийгэмд давамгайлж буй ёс суртахуун, соёлын хэм хэмжээ, үнэт зүйлсэд харшлахгүй оролцоог нийцтэй оролцоо гэнэ. Бүх ард түмний санал асуулгад оролцох нь нийцтэй улс төрийн оролцооны идэвхтэй хэлбэр юм.

Буруу хариултын тайлбар: Тогтоосон хэм хэмжээнээс гажсан, нийгмийн дийлэнх хэсгийн үнэлэмжийн баримжаанд тохирохгүй оролцоог нийцгүй оролцоо гэнэ.

29. Булдинг нарын эрдэмтэд эрх мэдлийг хэрэгжүүлэх хэлбэрүүдийг хэрхэн ангилсан бэ? /1 оноо/

- A. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх B. Хүч хэрэглэх, наймаалцах, үүрэг үүсгэх
C. Дагуулах ба хэрэгжүүлэх D. Эдийн засгийн, мэдээллийн, албадлагын
E. Ардчилсан ба ардчилсан бус

Зөв хариулт: В. Судлаач Булдинг нарын эрдэмтэд “Хүмүүс зорилгодоо хүрэхийн тулд эрх мэдлийн хүч хэрэглэх, намаалцах, үүрэг үүсгэх хэлбэрүүдийг ашигладаг” гэжээ.

Бүрүү хариултын тайлбар:

- A. Засаглал хуваарилах онолын дагуу эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гэж хуваарилдаг.
C. Америкийн судлаач Парсонс эрх мэдлийг дагуулах эрх мэдэл, хэрэгжүүлэх эрх мэдэл гэж ангилсан.
D. Эрх мэдлийг тулгуурлаж буй эх сурвалжаар нь эдийн засгийн, мэдээллийн, албадлагын гэж ангилдаг.
E. Эрх мэдлийг хэрэгжүүлж буй аргаар нь ерөнхийд нь ардчилсан ба ардчилсан бус гэж ангилдаг.

30. Улс төрийн системийн сонирхлыг нэгтгэх үйл ажиллагааг ямар улс төрийн институт хэрэгжүүлдэг вэ? /1 оноо/

- A. Улс төрийн нам B. Сонирхлын бүлэг C. Олон нийтийн байгууллага
D. Төрийн бус байгууллага E. Төр

Зөв хариулт: А. Улс төрийн системийн сонирхлыг нэгтгэх үйл ажиллагааг улс төрийн нам хэрэгжүүлдэг.

Бүрүү хариултын тайлбар: В, С, D Улс төрийн системийн сонирхлыг илэрхийлэх үйл ажиллагааг сонирхлын бүлэг, олон нийтийн байгууллага, төрийн бус байгууллага хэрэгжүүлдэг.

E. Улс төрийн системийн сонирхлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төр хэрэгжүүлдэг.

31. Улс төрийн системийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг харгалзах жишээтэй нь зөвөөр тохируулна уу. /2 оноо/

1	Оролт	a	Засгийн газар ээлжит хуралдаанаараа нийслэл хотын гэр хорооллын айл өрхөд цахилгааны үнэ тарифын хөнгөлөлт үзүүлэх шийдвэр гаргав
2	Гаралт	b	Сонгуулийн хуулийг өөрчлөх асуудлаар иргэний нийгмийн байгууллагууд УИХ-д шаардлага хүргүүлжээ
3	Эргэх холбоо	c	Иргэдээс гаргасан саналын дагуу парламент шинэ хууль баталсан нь холбоо олон түмний дэмжлэгийг хүлээжээ

- A. 1c2a3b B. 1a2c3b C. 1c2b3a D. 1b2c3a E. 1b2a3c

Зөв хариулт: Е. Оролт-Сонгуулийн хуулийг өөрчлөх асуудлаар иргэний нийгмийн байгууллагууд УИХ-д шаардлага хүргүүлжээ

Гаралт-Засгийн газар ээлжит хуралдаанаараа нийслэл хотын гэр хорооллын айл өрхөд цахилгааны үнэ тарифын хөнгөлөлт үзүүлэх шийдвэр гаргав

Эргэх холбоо-Иргэдээс гаргасан саналын дагуу парламент шинэ хууль баталсан нь олон түмний дэмжлэгийг хүлээжээ

Улс төрийн тогтолцоонд очиж байх ёстой мэдээллийг оролт гэнэ. Оролтод хамаарах шаардлага дэмжлэг нь засаглалын субъектийн зүгээс явуулж буй үнэт зүйлийн хуваарилалтын үндэслэлтэй холбоотой санал бодлын илэрхийллийн хэлбэр юм. Шаардлага нь улс төрийн тогтолцооны дотроос юм уу, түүнийг хүрээлэн байгаа янз бүрийн гадаад тогтолцооноос гарч буй тулгалтууд юм. Жишээ нь сонгуулийн хуулийг өөрчлөх гэх мэт. Улс төрийн тогтолцооны гаралт нь хэлбэрийн хувьд бүх нийтээр дагаж мөрдөх ёстой шийдвэр мөн. Гаралт нь шийдвэр үйлдлээр илэрнэ. Улс төрийн тогтолцоо нь оролтоороо дэмжлэг шаардлагыг хүлээн авч тэдгээрийг дотроо боловсруулан нийгмийн гишүүд бүгдээрээ биелүүлэх шийдвэрийг гаргаж байдаг. Гаралт нь энэхүү харилцан үйлдэл бүхий үйл явцын эцсийн цэг биш, тасралтгүй үргэлжлэх орчлын нэг л үе шат болно. Гаралт нь нийгмийн орчинд үйлчилсэний үр дүнд өмнө нь оролт дээр тавигдсан шаардлагыг үүсгэсэн шалтгаан нэг бол арилна, эсвэл хэвээр үлдэж ч мэднэ. Арилаагүй үлдсэн бол шаардлага дахин тавигдана. Улс төрийн тогтолцооны энэ мэт харилцан үйлчлэлийг эргэх холбоо гэж нэрлэнэ.

32. Төрийн салшгүй үндсэн 3 гол шинжийг гүйцээж бичээрэй /1 оноо/

1.Нийтлэг эрх мэдэл 2. Нутаг дэвсгэр 3.....

A.Соёлын хараат бус байдал B. Үзэл суртал C.Төрийн бэлгэдэл
D. Хүн ам E. Эдийн засгийн бие даасан байдал

Зөв хариулт :D. Төрийн салшгүй үндсэн 3 гол шинж нь нийтлэг эрх мэдэл, нутаг дэвсгэр, хүн ам юм

33. Улс орнуудыг төрийн засаглалын хэлбэрээр нь хэрхэн ангилдаг вэ? /1 оноо/

A.Тоталитар болон авторитар B, Нэгдмэл болон холбооны C. Ардчилсан ба ардчилсан бус
D. Хаант болон бүгд найрамдах E. Холбооны болон улсуудын холбооны

Зөв хариулт: D. Улс орнуудыг төрийн засаглалын хэлбэрээр нь хаант болон бүгд найрамдах гэж ангилдаг.

Бүрүү хариултын тайлбар:

A. Улс орнуудыг төрийн дэглэмийн хэлбэрээр нь ардчилсан ба ардчилсан бус гэж ангилдаг. Ардчилсан бус дэглэмийг тоталитар болон авторитар гэж ангилдаг.

B. Улс орнуудыг төрийн байгууламжийн хэлбэрээр нь нэгдмэл болон холбооны, улсуудын холбооны гэж ангилдаг.

C. Улс орнуудыг төрийн дэглэмийн хэлбэрээр нь ардчилсан ба ардчилсан бус гэж ангилдаг.

E. Улс орнуудыг төрийн байгууламжийн хэлбэрээр нь нэгдмэл болон холбооны, улсуудын холбооны гэж ангилдаг.

34. Шууд ардчиллын зарим давуу тал шинжүүдийг тоочихдоо түүний сул талыг дурдсан бол аль нь вэ? /1 оноо/
- A. Иргэдийн улс төрд оролцох идэвх, сонирхол өсдөг.
 - B. Хэн нэгэн хэтэрхий их эрх мэдэл эдлэхээс сэргийлдэг.
 - C. Бүх иргэдэд аливаа асуудлаар саналаа илэрхийлэх боломж олгодог.
 - D. Нийт иргэд тухайн асуудлаар шийдвэр гаргахад санал өгөх эрхтэй.
 - E. Хууль гаргахад ихээхэн хугацаа шаарддаг.

Зөв хариулт: E Хууль гаргахад ихээхэн хугацаа шаарддаг нь шууд ардчиллын сул тал юм.

Буруу хариултын тайлбар: Шууд ардчилал нь дараах давуу талуудтай байдаг.

- A. Иргэдийн улс төрд оролцох идэвх, сонирхол өсдөг.
 - B. Хэн нэгэн хэтэрхий их эрх мэдэл эдлэхээс сэргийлдэг.
 - C. Бүх иргэдэд аливаа асуудлаар саналаа илэрхийлэх боломж олгодог.
 - D. Нийт иргэд тухайн асуудлаар шийдвэр гаргахад санал өгөх эрхтэй.
35. Сонгодог ардчиллын онолыг тодорхойлох гол үзэл санаа аль нь вэ? /2 оноо/
- A. Төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд ард түмэн нийтээрээ оролцох эрхтэй байх
 - B. Нийгэм бол засаглалыг гартаа барьж буй удирдагч цөөнх, үлдсэн нь удирдуулагч олонхи гэсэн хоёр хэсэгт хуваагддаг.
 - C. Улс төрийн шийдвэр гаргахад бүх хүнийг оролцуулах боломжгүй.
 - D. Төр, засаг ард түмнийхээ өмнө биш харин нам, бүлэг гэх мэт субъектуудын өмнө хариуцлага хүлээх ёстой.
 - E. Нийгмийн доторх санаа бодлын илэрхийлэл болсон улс төрийн нам, бүлгүүдийн үүрэг чухал гэж үздэг.

Зөв хариулт: A. Сонгодог ардчиллын онолыг тодорхойлох гол үзэл санаа төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд ард түмэн нийтээрээ оролцох эрхтэй байх явдал юм.

Буруу хариултын тайлбар:

- B. Нийгэм бол засаглалыг гартаа барьж буй удирдагч цөөнх, үлдсэн нь удирдуулагч олонхи гэсэн хоёр хэсэгт хуваагддаг. Энэ нь элитийн ардчиллыг тодорхойлох үзэл санаа ЮМ.
- C. Улс төрийн шийдвэр гаргахад бүх хүнийг оролцуулах боломжгүй. Элит болон олон ургалч ардчиллын онолынхон энэхүү тайлбарыг хийдэг.
- D. Төр, засаг ард түмнийхээ өмнө биш харин нам, бүлэг гэх мэт субъектуудын өмнө хариуцлага хүлээх ёстой. Энэ нь олон ургалч ардчиллыг тодорхойлох үзэл санаа юм.
- E. Нийгмийн доторх санаа бодлын илэрхийлэл болсон улс төрийн нам, бүлгүүдийн үүрэг чухал гэж үздэг. Энэ нь олон ургалч ардчиллыг тодорхойлох үзэл санаа юм.

36. Аль нь сонгуулийн дийлэнх олонхийн тогтолцоог тодорхойлох вэ? /2оноо/
- A. Улс төрийн нам нь тодорхой тойргийг төлөөлөх хүмүүсийн нэрийг дэвшүүлдэг. Сонгогдохын тулд тухайн нэр дэвшигч тойрогтоо хамгийн олон санал авах ёстой.
 - B. Иргэд улс төрийн намын төлөө саналаа өгдөг бөгөөд нам тус бүр нэр дэвшигчдийн жагсаалт гаргадаг.
 - C. Парламентын суудлыг улс төрийн намуудад сонгуульд авсан саналтай нь хувь тэнцүүлэн хуваарилдаг.
 - D. Сонгогч дэмжиж буй намынхаа нэрсийн жагсаалтын төлөө саналаа гаргана.
 - E. Сонгуулийн дүн гарахад хувь хүн биш аль нэг нам хэдэн хувийн санал авсан нь тэргүүн зэргийн ач холбогдолтой.

Зөв хариулт: А. Улс төрийн нам нь тодорхой тойргийг төлөөлөх хүмүүсийн нэрийг дэвшүүлдэг. Сонгогдохын тулд тухайн нэр дэвшигч тойрогтоо хамгийн олон санал авах ёстой. Энэ нь сонгуулийн дийлэнх олонхийн тогтолцоо юм.

Буруу хариултын тайлбар: Дараах хариултын хувилбарууд нь сонгуулийн хувь тэнцүүлэх тогтолцоог илэрхийлэх шинж чанарууд юм.

В. Иргэд улс төрийн намын төлөө саналаа өгдөг бөгөөд нам тус бүр нэр дэвшигчдийн жагсаалт гаргадаг.

С. Парламентын суудлыг улс төрийн намуудад сонгуульд авсан саналтай нь хувь тэнцүүлэн хуваарилдаг.

Д. Сонгогч дэмжиж буй намынхаа нэрсийн жагсаалтын төлөө саналаа гаргана.

Е. Сонгуулийн дүн гарахад хувь хүн биш аль нэг нам хэдэн хувийн санал авсан нь тэргүүн зэргийн ач холбогдолтой.

37. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх эрх бүхий байгууллага аль нь вэ? /1 оноо/

А. Улсын ерөнхий прокурорын газар

В. Улсын дээд шүүх

С. Үндсэн хуулийн цэц

Д. Шүүхийн ерөнхий зөвлөл

Е. УИХ

Зөв хариулт: С. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх эрх бүхий байгууллага бол үндсэн хуулийн цэц юм. Монгол улсын үндсэн хуулийн 5-р бүлэг 64-р зүйл

Буруу хариултын тайлбар: Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх эрхийг улсын дээд шүүх, улсын ерөнхий прокурорын газар, шүүхийн ерөнхий зөвлөл, УИХ эдлэхгүй.

38. Аль нь ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарахгүй вэ? /1 оноо/

А. Улсын цол, одон медалиар шагнах

В. УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих

С. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх

Д. Улсын хил тогтоох

Е. Бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах

Зөв хариулт: Д Улсын хил тогтоох нь УИХ-н бүрэн эрхэд хамаарна. Монгол улсын үндсэн хуулийн 3-р бүлэг 25-р зүйл

Буруу хариултын тайлбар: Дараах хариултын хувилбарууд нь бүгд ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарна.

А. Улсын цол, одон медалиар шагнах

В. УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих

С. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх

Е. Бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах Монгол улсын үндсэн хуулийн 3-р бүлэг 33-р зүйл

39. Төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн захирал, багш нар төрийн албаны аль ангилалд хамаарах вэ? /1 оноо/

А. Төрийн онцгой алба

В. Төрийн улс төрийн алба

С. Төрийн захиргааны алба

Д. Төрийн тусгай алба

Е. Төрийн үйлчилгээний алба

Зөв хариулт: E. Төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн захирал, багш нар төрийн үйлчилгээний албаны ангилалд хамаарна. Монгол улсын төрийн албаны тухай хууль, Буруу хариултын тайлбар: Төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн захирал, багш нар нь төрийн улс төрийн, тусгай, захиргааны албаны албан тушаалтан биш.

40. Хуульчилсан акт тус бүрийг батлан гаргах төрийн албан тушаалтантай нь зөв тохируулна уу. /2оноо/

1	Тогтоол	a	Засгийн газрын агентлагийн дарга
2	Зарлиг	b	Засгийн газар
3	Тушаал	c	Ерөнхийлөгч

A. 1b2c3a B. 1a2c3b C. 1c2b3a D. 1b2a3c E. 1c2a3b

Зөв хариулт: A. Засгийн газар-Тогтоол, Ерөнхийлөгч- Зарлиг, Засгийн газрын агентлагийн дарга- Тушаал

41. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр УИХ ямар чиг үүрэг хүлээх вэ? /1 оноо/

- A. Хүүхдийн эрх зөрчигдсөн тухай нэхэмжлэлийг хүлээн авах
- B. Хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх
- C. Хүүхдийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх
- D. Хүүхдийн эрх зөрчигдсөн тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх
- E. Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой гэмт хэрэгт хяналт тавих, гэм бурууг тогтоох

Зөв хариулт: C. Хууль батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хууль эрх зүйн орчин бүрдүүлэх нь зөвхөн УИХ-д хамаарна.

Буруу хариултын тайлбар:

- A. Хүүхдийн эрх зөрчигдсөн тухай нэхэмжлэлийг хүлээн авах-Шүүх
- B. Хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх-Засгийн газар
- D. Хүүхдийн эрх зөрчигдсөн тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх-Шүүх
- E. Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой гэмт хэрэгт хяналт тавих, гэм бурууг тогтоох Шүүх,

42. Давж заалдах шатны шүүх аль нь вэ? /1 оноо/

- A. Сум буюу сум дундын шүүх
- B. Улсын дээд шүүх
- C. Үндсэн хуулийн цэц
- D. Нийслэлийн шүүх
- E. Дүүргийн шүүх

Зөв хариулт: D. Аймаг, нийслэлийн шүүх нь давж заалдах шатны шүүх юм.

Буруу хариултын тайлбар: Улсын дээд шүүх нь хяналтын шатны шүүх. Сум буюу сум дундын шүүх нь анхан шатны шүүх. Үндсэн хуулийн цэц нь үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх эрх бүхий байгууллага юм.

43. Иргэн С 2017 онд хувийн 2 өрөө орон сууцаа 70 сая төгрөгөөр худалдан борлуулжээ. Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлогоосоо хэдэн хувийг татварт төлөх вэ? /2оноо/

- A. 5%
- B. 2%
- C. 10%
- D. 12%
- E. 40%

Зөв хариулт: B. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод 2 хувиар татвар ногдуулна.

Буруу хариултын тайлбар:

- A. 5%-Спорт урлагийн тоглолтоос олсон орлогод 5 хувиар татвар ногдуулна.
- C. 10%-Хүн амын орлогын албан татварыг 10 хувиар ноогдуулна.
- D. 12%-Хийсвэр хувь
- E. 40%- Хонжворт сугалааны орлогод 40 хувиар татвар ногдуулна.

44. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар татварын хөнгөлөлт эдлэх нөхцөл, шаардлагыг хангасан иргэн аль нь вэ? /2оноо/

- A. Иргэн В хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 60 хувиар алдсан боловч хувиараа хөдөлмөр эрхэлж орлого олдог.
- B. Иргэн Д хонжворт сугалаанаас анх удаа 10 сая төгрөгийн хонжвор
- C. Иргэн Г төрийн албанд ажилладаг. 2017 онд анх удаа орон сууц худалдан авсан.
- D. Иргэн Н нэгэн компанид менежерээр ажилладаг. Түүний том хүү энэ жил их сургуульд элсэн суралцаж байна. Н хувиасаа сургалтын төлбөрийг нь төлсөн.
- E. Иргэн М 2017 онд 2 өрөө орон сууцаа худалдан борлуулж, үл хөдлөх хөрөнгийн татвар төлсөн.

Зөв хариулт: D. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар “Албан татвар төлөгчийн хүүхэд гадаад, дотоодын их дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид элсэн суралцаж байгаа бол түүний сургалтад төлсөн төлбөрийн хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ.

Буруу хариултын тайлбар:

- A. Иргэн В хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 60 хувиар алдсан боловч хувиараа хөдөлмөр эрхэлж орлого олдог. Хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлнө.
- B. Иргэн Д хонжворт сугалаанаас анх удаа 10 сая төгрөгийн хонжвор хожсон. Хонжворт сугалааны орлогод 40 хувиар татвар ногдуулна.
- C. Иргэн Г төрийн албанд ажилладаг. 2017 онд анх удаа орон сууц худалдан авсан. Хувь хүн өөрийн болон банк, санхүүгийн байгууллагаас зээлийн хөрөнгөөр хувьдаа орон сууц барих буюу худалдан авахад зориулсан 30 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлогыг татвараас чөлөөлнө.
- E. Иргэн М 2017 онд 2 өрөө орон сууцаа худалдан борлуулж, үл хөдлөх хөрөнгийн татвар төлсөн. Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлогод 2 хувиар татвар ногдуулна.

45. Өмчлөгч өмчлөлийн зүйлээ хуулиар тогтоосон тодорхой хэмжээ, хязгаарын хүрээнд эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломж, арчлах, хадгалах, эрсдэлийг хариуцах, аливаа халдлагаас хамгаалах тогтолцоог бий болгосон эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогцыг..... гэнэ. /1 оноо/

- A. Өмчийн хэв маяг
- B. Өмч хөрөнгө
- C. Өмчийн объект
- D. Өмчийн субъект
- E. Өмчийн эрх

Зөв хариулт: E. Өмчлөгч өмчлөлийн зүйлээ хуулиар тогтоосон тодорхой хэмжээ, Хязгаарын хүрээнд эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломж, арчлах, хадгалах, эрсдэлийг хариуцах, аливаа халдлагаас хамгаалах тогтолцоог бий болгосон эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогцыг өмчийн эрх гэнэ.

Буруу хариултын тайлбар:

- A. Өмчийн хэв маяг-Нийтийн, хувийн, холимог өмчийн хэв маяг.
- B. Өмч хөрөнгө-Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно
- C. Өмчийн объект- Өмчлөгчид бүхлээрээ буюу хэсгээрээ харъяалагдах газар, эд юмс гэх мэт бүхий л зүйлс өмчийн объект болно.
- D. Өмчийн субъект-Өмчлөгч нь өмчийн субъект бөгөөд өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хууль зүйн үүрэг бүхий хүн юм. Өмчийн субъект нь олон янз. Тухайлбал, хувь хүн, гэр бүл, байгууллага гэх мэт.

46. Хөрөнгийн ангилал болон харгалзах жишээг зөвөөр тохируулна уу. /2оноо/

1	Үл хөдлөх	a	Зохиогчийн эрх
2	Хөдлөх	b	Газар
3	Оюуны үнэт зүйл	c	Автомашин

A. 1b2c3a B. 1b2a3c C. 1a2c3b D. 1c2b3a E. 1c2a3b

Зөв хариулт: A. Үл хөдлөх-Газар, Хөдлөх-Автомашин, Оюуны үнэт зүйл-Зохиогчийн эрх

47. Олон улсын харилцааны агуулгад оролцогч субъектүүд зөвхөн үндэстэн улсуудын төр, засгийн харилцаа биш гэж үздэг эрдэмтэд цөөнгүй байдаг. Тэднийг тусгаар төр улс эсвэл эгэл нэгэн бие хүн гэж ялгаварлан аль нэгийг нь онцлон үзэж тусгай буюу давамгай үүрэг гүйцэтгэгчээр үзэж болохгүй. Бодгаль хүн ч гэсэн чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн үзсэн эрдэмтэн аль нь вэ? /1 оноо/

A. Н.Макиавелли B. Р.Арон C. Ж.Ж.Руссо D. Д.Сингер E. Дж.Локк

Зөв хариулт: D. Олон улсын харилцааны агуулгад оролцогч субъектүүд зөвхөн үндэстэн улсуудын төр, засгийн харилцаа биш гэж үздэг эрдэмтэд цөөнгүй байдаг. Тэднийг тусгаар төр улс эсвэл эгэл нэгэн бие хүн гэж ялгаварлан аль нэгийг нь онцлон үзэж тусгай давамгай үүрэг гүйцэтгэгчээр үзэж болохгүй. Бодгаль хүн ч гэсэн чухал үүрэг гүйцэтгэдэг гэж Д. Сингер үзсэн.
Буруу хариултын тайлбар: А.Н.Макиавелли-Нийтийн эрх ашгийн төлөө юуг ч хийсэн болно гэсэн зарчмыг төр ба улс төрд хамаатуулан хамгийн түрүүнд тууштай хэрэгжүүлсэн хүн бол Н. Макиавелли юм.

В. Р.Арон-Олон улсын харилцаа бол зөвхөн бие даасан тусгаар төр улсуудын хооронд л явагдаж байгаа үйл явц юм. Олон улсын харилцаанд төр улсуудын зүгээс дипломатч, эсвэл цэрэг хоёрын нэгийг сонгон оролцуулдаг гэж үзсэн эрдэмтэн.

С. Ж.Ж.Руссо-Сонгодог ардчиллын онолын төлөөлөгч эрдэмтэн

Е. Дж. Локк-Төрийн эрх мэдэл хуваарилах онолын төлөөлөгч эрдэмтэн

48. Олон улсын харилцаанд оролцогч субъектүүдийн хоорондын харилцааг зохицуулдаг хууль зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоог юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

A. Олон улсын харилцааны туйл B. Олон улсын ёс зүйн хэм хэмжээ
C. Олон улсын эрх зүй D. Олон улсын харилцааны хэлбэр
E. Олон улсын харилцааны тогтолцоо

Зөв хариулт: C. Олон улсын харилцаанд оролцогч субъектүүдийн хоорондын харилцааг зохицуулдаг хууль зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцооголон улсын эрх зүй гэнэ.

Буруу хариултын тайлбар: А. Олон улсын харилцааны туйл-Дэлхийн үндэстэн улсуудын төр, засгийн харилцаанд шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд гол чухал шийдвэр гаргахад бодитой нөлөөлөгч улс орнууд.

В. Олон улсын ёс зүйн хэм хэмжээ-Тусгаар тогтносон үндэстэн улсууд харилцан биенийхээ түүх, уламжлалт ёс заншил, тухайн үндэстэн ард түмний эрхэмлэдэг үнэт зүйлсийг хүндэтгэн үзэх ёстой.

Д. Олон улсын харилцааны хэлбэр-Улс төрийн, эдийн засгийн, соёлын, шинжлэх ухаан зэрэг харилцаанууд багтдаг.

Е. Олон улсын харилцааны тогтолцоо-орчин үеийн олон улсын харилцааг системийн онолын үүднээс авч үзвэл цогцолбор, тогтолцоот үйл явц.

49. 1945-1990 оны хоорондох хугацааг олон улсын харилцааны түүхэн үеийн аль ангилалд хамааруулах вэ? /1оноо/
- A. Дэлхийн I дайны үеийн олон улсын харилцаа
 - B. Хүйтэн дайны үеийн олон улсын харилцаа
 - C. Өнөө үеийн олон улсын харилцаа
 - D. Дэлхийн II дайны үеийн олон улсын харилцаа
 - E. Дэлхийн хоёр дайны хоорондох үеийн олон улсын харилцаа

Зөв хариулт: B. 1945-1990 оны хоорондох хугацааг олон улсын харилцаанд хүйтэн дайны үеийн олон улсын харилцаа гэж нэрлэдэг.

Буруу хариултын тайлбар:

- A. Дэлхийн I дайны үеийн олон улсын харилцаа: 1904-1918
- C. Өнөө үеийн олон улсын харилцаа: 1990 оноос хойш
- D. Дэлхийн II дайны үеийн олон улсын харилцаа: 1939-1945
- E. Дэлхийн хоёр дайны хоорондох үеийн олон улсын харилцаа: 1918-1939

50. Ромын болон Монголын эзэнт гүрнүүд нь тухайн цаг үеүддээ олон улсын үйл хэргийг дангаараа тодорхойлж байсан гэвэл энэ нь олон улсын харилцааны ямар туйлт тогтолцоо вэ? /1 оноо/
- A. Олон улсын харилцааны дөрвөн туйлт тогтолцоо
 - B. Олон улсын харилцааны хоёр туйлт тогтолцоо
 - C. Олон улсын харилцааны гурван туйлт тогтолцоо
 - D. Олон улсын харилцааны нэг туйлт тогтолцоо
 - E. Олон улсын харилцааны олон туйлт тогтолцоо

Зөв хариулт: D. Олон улсын харилцааны нэг тулт тогтолцоо: Олон улсын үйл хэргийг нэг их гүрэн эсвэл нэг эвсэл буюу холбоотнууд дангаараа тодорхойлж байдаг тогтолцоо юм.

Буруу хариултын тайлбар:

- A. Олон улсын харилцааны дөрвөн туйлт тогтолцоо-Олон улсын харилцааны туйлд ийм нэршил байхгүй.
- B. Олон улсын харилцааны хоёр туйлт тогтолцоо-дэлхийн улс орнууд хоёр том эвсэл буюу хоёр их гүрний ашиг сонирхолд үйлчилж, тэдгээр хоёр их гүрэн нь олон улсын харилцааны дэг журмыг тогтоодог тогтолцоо юм.
- C. Олон улсын харилцааны гурван туйлт тогтолцоо: Олон улсын харилцаанд гурван өөр ашиг сонирхол үйлчилдэг тогтолцоо юм.
- E. Олон улсын харилцааны олон туйлт тогтолцоо: Дэлхий ертөнцөд хүч тэнцүү олон улс, гүрэн бий болж, тэдгээр нь өөр хоорондоо ашиг сонирхол, зөрчлөөрөө үлэмж харилцан хамааралтай болж, түүний тэнцвэр дээр олон улсын харилцааны шинэ дэг журам тогтон

51. Олон улсын эрх зүйн хариуцлага хүлээлгэх гол үндэслэл болдог хууль зүйн үүднээс заавал биелүүлэх шинжтэй дэг журмыг заасан эрх зүйн зарим баримт бичгүүдийг дурдахдаа хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? /2оноо/
- A. Олон улсын шүүх арбитражын шийдвэр
 - B. Олон улсын гэрээ
 - C. Олон улсын байгууллагын заавал биелүүлэх шийдвэр
 - D. Олон улсын эрх зүйн нэг талын баримт бичиг
 - E. Олон улсын харилцааны ёс зүйн хэм хэмжээ

Зөв хариулт: Е. Олон улсын эрх зүйн хариуцлага хүлээлгэх гол үндэслэл болдог хууль зүйн үүднээс заавал биелүүлэх шинжтэй дэг журмыг заасан эрх зүйн зарим баримт бичигт олон улсын харилцааны ёс зүйн хэм хэмжээ хамаарахгүй

Буруу хариултын тайлбар: Олон улсын эрх зүйн хариуцлага хүлээлгэх гол үндэслэл болдог хууль зүйн үүднээс заавал биелүүлэх шинжтэй дэг журмыг заасан эрх зүйн баримт бичгүүдэд дараах баримт бичгүүд орно.

- A. Олон улсын шүүх арбитражын шийдвэр
- B. Олон улсын гэрээ
- C. Олон улсын байгууллагын заавал биелүүлэх шийдвэр
- D. Олон улсын эрх зүйн нэг талын баримт бичиг

52. Аль нь олон улсын эрх зүйн императив хэм хэмжээг тодорхойлох шинж чанар вэ? /2 оноо/

- A. Ямарч тохиолдолд гажиж үл болох хэм хэмжээ
- B. Субъект хоорондын харилцааны эрх, үүргийг тухайн хэм хэмжээний хүрээнд харилцан тохиролцох үндсэн дээр тогтоож болдог хэм хэмжээ
- C. Олон улсын харилцааны уян хэм хэмжээ
- D. Бусад улсын хууль ёсны ашиг сонирхолд хор хохирол учруулахгүй бол олон улсын эрх зүйд зааснаас өөр хэм хэмжээ тогтоон гэрээ байгуулж, тэр ёсоороо үйл ажиллагаа явуулж болно.
- E. Олон улсын түгээмэл эрх зүй ёсоор нутаг дэвсгэрийн ус бол тухайн улс гүрний нутгийн хэсэг учраас тэнд гадаадын хүмүүс загас агнахыг хориглоно. Гэвч хоёр улс өөрсдийн нутаг дэвсгэрийн усанд нөгөө этгээд нь загас агнахыг зөвшөөрсөн гэрээ байгуулж болно.

Зөв хариулт: А. Олон улсын эрх зүйн императив хэм хэмжээ гэдэг нь ямарч тохиолдолд гажиж үл болох хэм хэмжээ юм.

Буруу хариултын тайлбар: Олон улсын эрх зүйн диспозитив хэм хэмжээг тодорхойлох шинж чанарууд:

- B. Субъект хоорондын харилцааны эрх, үүргийг тухайн хэм хэмжээний хүрээнд харилцан тохиролцох үндсэн дээр тогтоож болдог хэм хэмжээ
- C. Олон улсын харилцааны уян хэм хэмжээ
- D. Бусад улсын хууль ёсны ашиг сонирхолд хор хохирол учруулахгүй бол олон улсын эрх зүйд зааснаас өөр хэм хэмжээ тогтоон гэрээ байгуулж, тэр ёсоороо үйл ажиллагаа явуулж болно.
- E. Олон улсын түгээмэл эрх зүй ёсоор нутаг дэвсгэрийн ус бол тухайн улс гүрний нутгийн хэсэг

53. Орчин үед улс орнуудын харилцаанд идэвхтэй үйлчилсээр байгаа эрх зүйн зарим тулгуур зарчмуудыг дурдахдаа хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/

- A. Маргаантай асуудлыг энх тайвнаар зохицуулах
- B. Хүч үл хэрэглэх, айлган сүрдүүлэхгүй байх
- C. Улс орнуудын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх
- D. Улс орнууд биенийхээ дотоод хэрэгт оролцох
- E. Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэх

Зөв хариулт: D. Улс орнууд биенийхээ дотоод хэрэгт оролцох нь орчин үед улс орнуудын харилцаанд идэвхтэй үйлчилсээр байгаа эрх зүйн тулгуур зарчмуудад хамаарахгүй.

Буруу хариултын тайлбар: Орчин үед улс орнуудын харилцаанд идэвхтэй үйлчилсээр байгаа эрх зүйн тулгуур зарчмууд:

- A. Маргаантай асуудлыг энх тайвнаар зохицуулах
- B. Хүч үл хэрэглэх, айлган сүрдүүлэхгүй байх
- C. Улс орнуудын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх
- E. Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэх НУ VI. УБ., 2017. 177 дахь тал

54. НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд тэдгээрийн нэршлийг зөв харгалзуулна уу. /2оноо/

1	ЮНЕСКО	a	НҮБ-ын Хүүхдийн сан
2	ЮНИСЕФ	b	НҮБ-ын Хүн Амын Сан
3	UNFPA	c	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, Соёлын байгууллага

A. 1a2c3b B. 1b2a3c C. 1c2a3b D. 1c2b3a E. 1b2c3a

Зөв хариулт: C. ЮНЕСКО-НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, Соёлын байгууллага, ЮНИСЕФ-НҮБ-ын Хүүхдийн сан, UNFPA-НҮБ-ын Хүн Амын Сан

55. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол улсын гадаад харилцааны бодлогын мөн. /1 оноо/

A. Хоёр дахь зорилт B. Эн тэргүүний зорилт C. Гурав дахь зорилт
D. Дөрөв дэх зорилт E. Тав дахь зорилт

Зөв хариулт: B. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн, Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал

56. Монгол улсын хувьд ихээхэн ач холбогдолтой олон улсын харилцааны бүс нутгууд болон тэдгээрт харъяалагдах улс орнуудыг зөв харгалзуулна уу. /2оноо/

1	Зүүн ба зүүн өмнөд ази	a	Тажикстан, Казакстан
2	Зүүн хойд ази	b	БНСУ, Япон
3	Төв ба Евроази	c	Филиппин, Малайз

A. 1a2b3c B. 1b2a3c C. 1c2a3b D. 1c2b3a E. 1b2c3a

Зөв хариулт: D. Зүүн ба зүүн өмнөд ази-Филиппин, Малайз, Зүүн хойд ази-БНСУ, Япон, Төв ба Евроази-Тажикстан, Казакстан

2.1 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. /6 оноо/

a	Төрөлх статус	1	Хоёр ба түүнээс дээш хоорондоо нийцгүй үүргийн эсрэг тэсрэг шаардлагыг зайлшгүй биелүүлэх нөхцөл
b	Олдмол статус	2	Нийгмийн байр суурьт байх ёстой буюу зохимжтой гэж үзсэн үйл байдал
c	статус	3	Хүний амьдралын тодорхой нэгэн үед шийдвэрлэх үүрэг бүхий нэг нь нөгөөгөөсөө илүү чухал байдгийг нийгэмд хүлээн зөвшөөрсөн нийгмийн байр суурь
d	Мастер статус	4	Тухайн нийгмийн тогтолцоонд аливаа хувь хүний эзэлж буй байр суурь, түүнд хамаарах эрх, үрэг, бусдын зүгээс хандах хандлагын цогц
e	Үүрэг	5	Хүний өөрийнх нь хичээл зүтгэл, чармайлтаар олж авдаг нийгмийн байр суурь
f	Үүргийн зөрчилдөөн	6	Тодорхой нэг хүний өвөрмөц авъяас чадвар, өөрт нь заяагдмал, өөрөө сонгох боломжгүй байдаг нийгмийн байр суурь

Зөв хариулт:

a-6. Тодорхой нэг хүний өвөрмөц авъяас чадвар, өөрт нь заяагдмал, өөрөө сонгох боломжгүй байдаг нийгмийн байр суурь,
b-5. Хүний өөрийнх нь хичээл зүтгэл, чармайлтаар олж авдаг нийгмийн байр суурь,
c-4. Тухайн нийгмийн тогтолцоонд аливаа хувь хүний эзэлж буй байр суурь, түүнд хамаарах эрх, үүрэг, бусдын зүгээс хандах хандлагын цогц,
d-3. Хүний амьдралын тодорхой нэгэн үед шийдвэрлэх үүрэг бүхий нэг нь нөгөөгөөсөө илүү чухал байдгийг нийгэмд хүлээн зөвшөөрсөн нийгмийн байр суурь
, e-2. Нийгмийн байр суурьт байх ёстой буюу зохимжтой гэж үзсэн үйл байдал,
f-1. Хоёр ба түүнээс дээш хоорондоо нийцгүй үүргийн эсрэг тэсрэг шаардлагыг зайлшгүй биелүүлэх нөхцөл

2.2 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. /6оноо/

a	Дэд соёл	1	Нийгмийн элит хэсэг юмуу түүний захиалгаар мэргэжлийн уран бүтээлчид бүтээдэг соёл
b	Ардын соёл	2	Тодорхой цаг үед нийгмийн гишүүдийн дийлэнхийн амьдрах зан үйл, үйлдлийн загварыг тодорхойлогч соёл
c	Сонгодог соёл	3	Нийгмийг бүрдүүлэгч бүлгүүдийг ялгаж байгаа хэм хэмжээ, үнэт зүйлсийн систем
d	Нийтийн соёл	4	Зонхилох соёлтой зөрчилдөж байдаг соёл
e	Серег соёл	5	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл түгэн дэлгэрч, нийгмийн бүхий л давхаргад хүртээмжтэй болсон ХХ зууны дунд үед үүссэн соёл
f	Зонхилох соёл	6	Тухайн улс үндэстний ам дамжин уламжлагдан ирсэн үлгэр, домог гэх мэтийг багтаасан өвөрмөц соёл

Зөв хариулт:

a-3. Нийгмийг бүрдүүлэгч бүлгүүдийг ялгаж байгаа хэм хэмжээ, үнэт зүйлсийн систем,
b-6. Тухайн улс үндэстний ам дамжин уламжлагдан ирсэн үлгэр, домог гэх мэтийг багтаасан өвөрмөц соёл,
c.1. Нийгмийн элит хэсэг юмуу түүний захиалгаар мэргэжлийн уран бүтээлчид бүтээдэг соёл,
d-5. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл түгэн дэлгэрч, нийгмийн бүхий л давхаргад хүртээмжтэй болсон ХХ зууны дунд үед үүссэн соёл,
e-4. Зонхилох соёлтой зөрчилдөж байдаг соёл
, f-2. Тодорхой цаг үед нийгмийн гишүүдийн дийлэнхийн амьдрах зан үйл, үйлдлийн загварыг тодорхойлогч соёл :

2.3 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. /6 оноо/

a	Мөнгөний тэлэх бодлого	1	Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх
b	Мөнгөний хумих бодлого	2	Эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин байнга өсч, мөнгө үнэгүйдэх
c	Төрийн мөнгө зээлийн бодлого	3	Эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин
d	Инфляци	4	Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг багасгах

e	Төрийн сангийн бодлого	5	Гүйлгээнд мөнгө нэмж оруулах буюу мөнгөний нийлүүлэлтийг нэмэх
f	Дефляци	6	Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх

Зөв хариулт:

- a-5. Гүйлгээнд мөнгө нэмж оруулах буюу мөнгөний нийлүүлэлтийг нэмэх,
b- 4. Гүйлгээнээс мөнгө татах буюу мөнгөний нийлүүлэлтийг багасгах,
c-6. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх,
d-2. Эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин байнга өсч, мөнгө үнэгүйдэх,
e-1. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх,
f-3. Эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин буурах

2.4 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. /6 оноо/

a	Сонгууль	1	Тухайн улсын нийт иргэд сонгуульд оролцох эрхтэй байх
b	Сонгуулийн бүх нийтийн зарчим	2	Санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт нийтийн зарчим хийх
c	Сонгуулийн тэгш эрхийн зарчим	3	Сонгуулийн эцсийн үр дүн иргэдийн санал эрхийн зарчим хураалтаар шийдэгдэх
d	Шууд сонгох зарчим	4	Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй, санал бүр ижил жинтэй байх
e	Чөлөөтэй Сонгох зарчим	5	Сонгогч хэний ч нөлөөнд автахгүй, зөвхөн өөрийн зарчим үзэмжээр саналаа өгөх
f	Саналаа нууцаар	6	Сонгуульд оролцох, эс оролцох, хэний ч шахалтад гаргах зарчим орохгүйгээр саналаа чөлөөтэй илэрхийлэх

Зөв хариулт:

- a-2. Санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийх,
Б-1. Тухайн улсын нийт иргэд сонгуульд оролцох эрхтэй байх
С-4. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй, санал бүр ижил жинтэй байх,
d-3. Сонгуулийн эцсийн үр дүн иргэдийн санал хураалтаар шийдэгдэх,
e-6. Сонгуульд оролцох, эс оролцох, хэний ч шахалтад орохгүйгээр саналаа чөлөөтэй илэрхийлэх,
f.5. Сонгогч хэний ч нөлөөнд автахгүй, зөвхөн өөрийн үзэмжээр саналаа өгөх